



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 13

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах, үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 сарын 27-ны өдрийн 636 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арвангуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 20,570,175.04 /хорин сая таван зуун далан мянга нэг зуун далан таван төгрөг дөрвөн мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, 5 нэр төрлийн 41 ширхэг хөрөнгийг нэгдүгээр хавсралтын дагуу акталж, данснаас хасах, нийт 8,394,200 /найман сая гурван зуун ерэн дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгийн балансын үнэтэй, 4,197,100 /дөрвөн сая нэг зуун ерэн долоон мянга нэг зуун/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 2 ширхэг хөргөгчийг хоёрдугаар хавсралтаар “Боржигон мандал”, “Өлзийт мандал” өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үндсэн хөрөнгийн дансанд тус тус балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Алтантөгс), “Боржигон мандал” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Ө.Нямсүрэн), “Өлзийт мандал” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Т.Урангоо) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Актлах хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор актлах;

2.2 Шилжүүлэх хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн
13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АКТЛАХ ХӨРӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Актлах төрөл 1 устгах 2 худалдах 3 сэлбэг материал түүхий эд болгох 4 бусад	
1	Тог баригч	2019.06.30	ш	1	251,212.00	251,212.00	175,848.54	75,363.46	1	
2	Тог баригч	2019.06.30	ш	12	400,410.90	4,804,930.80	960,986.16	3,843,944.64	1	
3	Хөргөгч	2009.12.31	ш	1	635,000.00	635,000.00	126,999.96	508,000.04	1	
4	Компьютер	2016.09.29	ш	8	1,736,379.03	13,891,032.24	2,778,206.46	11,112,825.78	1	
5	Цонхны хөшиг	2013.12.31	ш	19	52,000.00	988,000.00	625,733.46	362,266.54	1	
Нийт дүн										
					41	20,570,175.04 /хорин сая таван зуун далан мянга нэг зуун далан таван төгрөг Дөрвөн мөнгө/ төгрөг	4,667,774.58 /дөрвөн сая зургаан зуун жаран долоон мянга долоон зуун далан дөрвөн төгрөг тавин найман мөнгө/ төгрөг	15,902,400.46 /арван таван сая есөн зуун хоёр мянга дөрвөн зуун төгрөг дөчин зургаан мөнгө/ төгрөг		

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
13 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Хөргөгч VLS-064A	2021.04.02	ш	1	4,197,100.00	2,098,550.00	2,098,550.00	"Боржигон мандал" ӨЗМТөв
2	Хөргөгч VLS-064A	2021.04.02	ш	1	4,197,100.00	2,098,550.00	2,098,550.00	"Өлзийт мандал" ӨЗМТөв
Нийт дүн					8,394,200.00 /найман сая гурван зуун ерэн дөрвөн мянга хоёр зуу/ төгрөг	4,197,100 /дөрвөн сая нэг зуун ерэн долоон мянга нэг зуун/ төгрөг	4,197,100 /дөрвөн сая нэг зуун ерэн долоон мянга нэг зуун/ төгрөг	